

МУГД СЭМЖИДСҮРЭНГИЙН ГАН-ЭРДЭНИЙН НЭРЭМЖИТ  
ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН БАГА НАСНЫ УАШТ-2023



Бага Насны  
УАШТ ★ 2023

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:



6 сар  
14, 15, 16

УЛААНБААТАР ХОТ  
СПОРТЫН ТӨВ ОРДОН

ДЭМЖИГЧИД:



Mongolia Taekwondo channel



www.facebook.com/MongolTaekwondo



www.mongol-taekwondo.com

МУГД СЭМЖИДСҮРЭНГИЙН ГАН-ЭРДЭНИЙН НЭРЭМЖИТ  
ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН  
“БАГА НАСНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН-2023”  
УДИРДАМЖ

**ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:**

- Таеквондогийн спортыг сурталчилах,
- Монгол улсад олимпийн таеквондогийн спортыг түгээн дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах.
- Баг тамирчдын ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох.

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

Зохион байгуулагч	Монголын Таеквондогийн Холбоо
Холбоо барих	8010-0471
E-mail	<a href="mailto:mongoliataekwondo@gmail.com">mongoliataekwondo@gmail.com</a>
Facebook хуудас	<a href="http://www.facebook.com/mongoliataekwondo/">www.facebook.com/mongoliataekwondo/</a>
Бүртгэлийн систем	www.mongol-taekwondo.com

**ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:**

Өдөр	Хөтөлбөр	Байршил
6 сарын 2-9	• Бүртгэл	www.mongol-taekwondo.com
6 сарын 13	• Тамирчдын жин үзнэ	Улаанбаатар хотын 4 бүсэд нэгэн зэрэг.
	• Тэмцээний техникийн зөвлөгөөн, сугалаа	Үндэсний шигшээ багийн зааланд
6 сарын 14-16	• Тэмцээн	Спортын төв ордны А зааланд

- ❖ Заасан хугацаа хэтэрсэн багийн мэдүүлгийг хүлээн авахгүй.
- ❖ Тэмцээнд оролцогч тамирчид лицензтэй байх шаардлагатай.
- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.
- ❖ Бүртгэл хаагдсаны дараа оролцогч тамирчдын жин үзүүлэх байршил болон хугацааг олон нийтэд мэдээлнэ. (оролцогч байгууллагуудын бүсчлэл, оролцогчдын тоог харгалзан үзнэ)

## ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

### 1) ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна, зөвхөн тэр бүсээ бүсэлж тухайн бүсний ангилалдаа өрсөлдөнө.
- Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- Тамирчин нь Монголын таеквондогийн цахим бүртгэлийн системд бүртгүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна. Хэрэв лиценз шинээр авах эсвэл сунгуулах шаардлагатай бол сорил тэмцээнд бүртгүүлэхээс өмнө лицензийн хураамж болох 50.000₮ (тавин мянган төгрөг) Хаан банкны 5431161905 тоот Монголын таеквондогийн холбооны дансанд шилжүүлснээр тэмцээнд оролцох эрх нээгдэнэ.
- Тэмцээнд оролцогч тамирчин бүр таеквондогийн ёс, дэг журмыг чанд баримтлан, хувийн ариун цэврийг дээд зэргээр хангасан байх шаардлагатай. Үүнд: гар, хөлийн хумсыг засаж, элдэв бөгж, хүзүүний зүүлт зэргийг хэрэглэхгүй байх
- Тэмцээнд оролцогч багууд тамирчдынхаа байр, хоолыг өөрсдөө хариуцна.
- Тамирчдын жинг олон кг-р хасахгүй байхыг нийт багш, дасгалжуулагч нарт онцгой анхааруулж байна
- Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгээс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
- Шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай.
- Тулаан А (хар бүстэй тамирчид), В (улаан, цэнхэр бүстэй тамирчид), С (ногоон, шар бүстэй тамирчид) гэсэн үндсэн гурван ангиллаар явагдана.
- А ангиллын тулаан Daedo цахим онооны системээр явагдах бол В болон С ангиллын тамирчдын тулаан цахим бус энгийн хамгаалалт дээр явагдана.
- **Өмнө нь бага насны УАШТ-д С ангилалд медаль хүртэж байсан тамирчин нь энэ удаад С ангилалдаа дахин орж болохгүй, В эсвэл А ангилалд орох ёстой. Харин В ангилалд медаль хүртэж байсан бол энэ удаад зөвхөн А ангилалд орох боломжтой.**
- Тэмцээнд оролцох тамирчид Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдана.



## 2. ЖИНГИЙН ДАРААЛАЛ

Бага нас (8-9 нас) 2014-2015 онд төрсөн тамирчид

Эр		Эм	
-24кг	24кг хүртэлх	-23 кг	23кг хүртэлх
- 26кг	24кг жингээс 26кг жингийн хооронд	-25 кг	23кг жингээс 25кг жингийн хооронд
- 28кг	26кг жингээс 28кг жингийн хооронд	- 27 кг	25кг жингээс 27кг жингийн хооронд
- 30кг	28кг жингээс 30кг жингийн хооронд	- 29 кг	27кг жингээс 29кг жингийн хооронд
+ 30кг	30кг жингээс дээш жинтэй тамирчид	+29кг	29кг жингээс дээш жинтэй тамирчид

Бага нас (10-11нас) 2012-2013 онд төрсөн тамирчид

Эр		Эм	
- 26 кг	26кг хүртэлх	-25 кг	25кг хүртэлх
- 29 кг	26кг жингээс 29кг жингийн хооронд	-28 кг	25кг жингээс 28кг жингийн хооронд
- 32 кг	29кг жингээс 32кг жингийн хооронд	- 31 кг	28кг жингээс 31кг жингийн хооронд
- 35 кг	32кг жингээс 35кг жингийн хооронд	- 34 кг	31кг жингээс 34кг жингийн хооронд
- 38 кг	35кг жингээс 38кг жингийн хооронд	- 37 кг	34кг жингээс 37кг жингийн хооронд
+38 кг	38кг жингээс дээш жинтэй тамирчид	+37кг	37кг жингээс дээш жинтэй тамирчид

*Тайлбар: Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.*

## 3. БҮСНИЙ АНГИЛАЛ

**А ангилалд** хар бүс, куккивоны дантай /room/ тамирчид

**В ангилалд** хөх, улаан бүстэй тамирчид

**С ангилалд** шар, ногоон бүстэй тамирчид тус тус оролцох эрхтэй.

## 4. Оролцогчийн ХУРААМЖ

Тэмцээнд оролцогч нэг тамирчны дэвжээний төлбөр

- Улаанбаатар хотын тамирчид дэвжээний төлбөр 40000 (дөчин мянга) төгрөг,

Хөдөө, орон нутгийн тамирчид

- Улаанбаатар хотоос 1000 км дотогш 30000 (гучин мянга) төгрөг,

- Улаанбаатар хотоос 1000 км гадагш 25000 (хорин таван мянга) төгрөг

**Оролцогчийн хураамж хүлээн авах данс:**

Хаан банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

## 5. ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН ГАРГАХ

- Тэмцээнийг дэлхийн таеквондогийн холбооны дүрмийн дагуу хасагдах системээр явуулж, 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан шагнаж урамшуулна.
- Багийн дүнг ангилал тус бүрд медалийн чанараар дүгнэнэ.
- Спортын цол, зэргийн болзолд А ангиллыг тооцно. В, С ангилал спортын цол, зэргийн болзолд хамаарахгүй болно.

## 6. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- Жиндээ эхний 3 байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.
- Багийн дүнгээр ангилал тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн багуудыг цом, медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулна.
- Мөн шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчин, шүүгч, дасгалжуулагчийг цом, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -